



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 541

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн охин компани “Ховд цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,000,000.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины 3 дахь дуудлагын худалдааг зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. “Ховд цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ш.Арстанд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20 -ны өдрийн
5.4 дугаар тогтоолын хавсралт

**"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн охин компани
"Ховд цахилгаан түгээх сүлжээ" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиг лалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 229 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота креста, 53-08 ХОА, суудлын, GX100- 6052511	1997/2010	173206	5,000,000.00	1,500,000.00	750,000.00
	Нийт дүн			5,000,000.00 (таван сая)	1,500,000.00 (нэг сая таван зуун мянган)	750,000.00 (долоон зуун тавин мянган)